

**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК- НИЙ АЖИЛЧДЫН ХОТХОНЫ
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

	Зураг төсөв, барилга угсралтын ажил хийж гүйцэтгэх үндэслэл:	“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ний Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажил
	Барилга байгууламжийн байршил:	Өмнөговь аймгийн Цогтцэций сум. 66 га газарт
	Барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал:	Ажилчдын хотхоны барилга 300 хүний багтаамжтай зоорьгүй 3 давхар барилга нь тэнхлэгэрээ 44.40*58.20м хэмжээтэй, голдоо 26.40*33.00м хэмжээтэй, голдоо двор бүхий 4 блокоос бүрдэх цутгамал төмөр бетон каркасан хийцлэлтэй. 1-р давхрын өндөр 3.30м, 2 болон 3-р давхар 3.0м өндөртэй, 1 үндсэн гол орц, 2 туслах орц гарцтай, 4 шатны хонгилтой, ажилчдын амрах талбай, цөөрөм зэрэг төлөвлөгдсөн. Авто машины гражийн барилга нь тэнхлэгээрээ 36*18м хэмжээтэй 1 давхар цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй. Том автомашины зогсоол, агуулах, цэвэр усны бак байхаар төлөвлөгдсөн. Гадна зам талбайн тохижилтын ажилд өнгөт хавтантай явган зам талбай, авто зам, зогсоолын талбай, авто, явган замын хашлага, модон гүүр, зүлэгжүүлэх талбай, саравч, сандал, усан оргилуур, мод, чулуун зам, гэрэлтүүлэг зэрэг төлөвлөгдсөн.
	Барилгын технологийн шийдэл:	Барилгын үндсэн хийц нь төмөр бетон каркас болон чулуун хөвөн дулаалгатай хөнгөн цагаан нийлмэл хавтан /Aluminium composite panel/ болон модон хуванцарын нийлмэл хавтан /Wood plastic composite/- г хослуулсан, цутгамал төмөр бетон хучилттай, цутгамал төмөр бетон баганан суурьтай бөгөөд гадна, дотор хана полистрол бетон хавтангаар хийж гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ Барилгын тухай хууль, бусад хуулиуд, БНБД-д заасан норм, шаардлагад нийцүүлэн ЕГ Шифр ГА-08/2018 зураг төслийн дагуу, захиалагчийн шаардлагад нийцүүлэн ажиллах шаардлагатай. Зураг төсөлд заагдсан материал бүтээц, эдлэхүүнийг зөвхөн захиалагч болон зураг төслийг зохиогч байгууллагын зөвшөөрлөөр солих ба хяналтын хуудас /check list/ зөвшөөрөгдсөний дараа дараагийн үе шатны ажлуудыг эхлүүлнэ.
	Барилгын үндсэн бүтээц, хийцийн шийдэл:	<u>АЖИЛЧДЫН ХОТХОН</u> Газар шороо, буурь суурийн ажил: Барилгын буурь суурьт хэрэглэх хөрс, шороо, материал эдлэхүүн, хийц бүтээцийг батлагдсан зураг, инженер геологийн дүгнэлтийг үндэслэнэ. Төмөр бетон ба бетон бүтээцийн ажилд: Барилгын даацын үндсэн бүтээц нь цутгамал төмөр бетон араг бүтээц байна. Батлагдсан зургийн дагуу бетон, зуурмагын марк, бат бэхийг бүрэн хангах, стандартад тохирсон элс, хайрга, дайргыг бэлтгэж хэрэглэнэ. Лабораторийн шинжилгээтэй цементийг барилгад хэрэглэнэ. Арматур нь зургийн дагуу стандартын шаардлага хангасан, баталгаажсан гэрчилгээтэй байна. Ил далд ажлыг акт, фото зургаар баталгаажуулна. Хана хамар ханын өрөгт бүтээцийн ажил:

		Барилгын гадна ханыг 24см зузаантай хөнгөн бетон блокон дүүргэгчтэй ханатай, 15см зузаантай галд тэсвэртэй стандарт шаардлага хангасан чулуун хөвөн дулаалгатай, металл өнгөлгөөтэй. Гадна хана нь 24см зузаантай полистрол бетон, багана ба дам нуруунаас 20мм-ийн зайтай өрж зай завсрыг уян зөөлөн материалаар чигжинэ. Дотор хамар ханыг 10см болон 20см-ийн зузаантай полистрол бетон хавтан байхаар тус тус төлөвлөгдсөн. Барилгын дуу, дулаан тусгаарлалтын ажилд БНБД 31-08-05-ийг мөрдөж ажиллах ба дуу дулаан тусгаарлах материал, эдлэхүүн, эдлэлүүд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн баримт бичгийн шаардлага хангасан байх. Гадна заслал: Барилгын гадна өнгөлгөө хөнгөн цагаан нийлмэл хавтан болон шилэн фасадтай байх ба зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. Газраас дээш гарч буй цоколийн хэсэг болон гадна довжоо пандусны түшиц хана зэргийг чулуун хавтангаар өнгөлнө. Гадна заслалын материал өөрчлөх, худалдан авалт хийгдэхээс өмнө захиалагч болон зохиогчтой зөвшилцөн зөвшөөрөл авч гүйцэтгэнэ. Дотор заслал: Дотор заслын ажлыг гүйцэтгэхэд ханын гадаргууг сайжруулсан шавардлага, сантехник, цахилгааны ажлуудыг дуусгасан байх ба зурагт заасны дагуу гүйцэтгэнэ. Барилгын дотор заслалд Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт шаардлагад нийцэх, хүний биед хор нөлөөгүй сайн чанарын материал ашиглах. Дотор заслалын материал өөрчлөх, худалдан авалт хийгдэхээс өмнө захиалагч болон зохиогчтой зөвшилцөн зөвшөөрөл авч гүйцэтгэнэ. Цонх хаалга: Барилгад хэрэглэх хаалга, цонх, шилэн ханыг стандарт шаардлагад нийцсэн материал сонгох ба ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. Хучилт: Цутгамал төмөр бетон хучилттай төлөвлөгдсөн тул ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. Дээвэр: Барилгын дээвэр хуйлмал, хавтгай хучилттай байх ба борооны усыг дотуур зайлуулна. Дээврийг хөөсөн полистрол /XPS, нягт 36кг/м3/ хавтангаар дулаална. Дээврийн материалыг өөрчлөх бол худалдан авалт хийгдэхээс өмнө захиалагч болон зургийн зохиогчтой зөвшилцөн зөвшөөрөл авч гүйцэтгэнэ. Төмөр бетон арагт бүтээц: Барилгын даацын үндсэн бүтээц нь цутгамал төмөр бетон арагт бүтээц байх ба B25 ангийн бетон, ГОСТ5781-82-ийн A240, A400 ангийн арматураар зураг төсөлд тооцсон болно. Батлагдсан зургийн дагуу узель-ийн бетон зуурмагаар гүйцэтгэнэ. Халаалт,агаар сэлгэлт: Батлагдсан зургийн дагуу барилгын халаалтыг нэгдсэн уурын зуухнаас хангана. Барилгын халаалтын систем нь бие даасан 2 системтэй байх ба доороос түгээлттэй, мухардмал эргэлттэй, хоёр хоолойт ба коллекторын системтэй байхаар төлөвлөгдсөн.
--	--	--

		Агаар сэлгэлтийг ердийн болон мехнаик ажиллагаатай системтэй байхаар төлөвлөгдсөн. Цэвэр, бохир ус : Ахуйн ус хангамжийн систем нь гүний худагнаас хангагдана. Хэргэлээний халуун усыг тогооны барилгад байрлах ус халаагчаас хангана. Барилга доторх ус хангамжийг ахуйн болон галын ус хангамжийн системтэй байхаар төлөвлөж, барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар нь нэгтгэн зайлуулахаар төлөвлөсөн ба батлагдсан зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. Цахилгаан хангамж: Барилгын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны II зэрэгт хамрагдах ба тэжээлийг гүн газардуулсан нейтральтай бие биеэ нөөцлөх 2,4,6 хос кабель шугамаар тэжээхээр төлөвлөж, газардуулга, аянга хамгаалалтын төлөвлөсөн ба зургийн дагуу гүйцэтгэнэ. Холбоо дохиолол: Барилгад телефон холбоо, интернет сүлжээ, кабелийн телевиз, галын дохиолол, ажиглалт хяналтын систем, зарлан мэдээлэх системийг тус тус хийхээр төлөвлөгдсөн тул ажлын зургийн дагуу гүйцэтгэнэ. Хаяавч: Барилгын эргэн тойронд 1.0м өргөнтэй В10 ангийн бетон манаасыг барилгаас гадагш налуутай хийж гүйцэтгэх ба орчны тохижилтын ажлын зургын дагуу гүйцэтгэнэ. <u>АВТО ГРАЖИЙН БАРИЛГА</u> Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурь Даацын үндсэн бүтээц: Цутгамал төмөр бетон арагт бүтээц Гадна хана: 240мм зузаантай хөнгөн бетон блокон дүүргэгч хана, 150мм зузаантай чулуун хөвөн дулаалгатай Хучилт: Цутгамал төмөр бетон хучилт Дээвэр: Хавтгай дээвэр Халаалт,агаар сэлгэлт: Төлөвлөж буй барилгын халаалтыг доогуур түгээлттэй, хоёр хоолойт мухардмал эргэлттэй, агаар сэлгэлтийг ердийн болон механик ажиллагаатай системтэй байхаар төлөвлөгдсөн <u>ГАДНА ЗАМ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ</u> Барилгын ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу : - Авто зам талбай /асфальт бетон / -9101,65м² - явган зам талбай /өнгөт хавтан/- 3702,72м² - Авто замын хашлага 2024,75м - Явган замын хашлага 1171,9м - Модон гүүр-2ш - Зүлэгжүүлэх талбай – 5263,12м² - Саравч /модон/ - 2ш - Сандал /2.47*0.48*0.45/ - 20ш - Усан оргилуур - 2ш - Мод / 3-4метрийн өндөртэй говийн нөхцөлд ургах боломжтой/ - 200ш - Чулуун зам - 873м² - Нарны зай хураагууртай явган замын гэрэл – 150ш
--	--	---

		- Нарны зай хураагууртай замын гэрэл – 48ш зэргийг орчны тохижилтийн ажлыг зургын дагуу хийж гүйцэтгэнэ.
	Төслийн үе шат, хугацаа	Барилга угсралтын ажил: Нэг үе шаттай - Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэх, технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт бичиж баталгаажуулан, материалын сертификат, /гүйцэтгэлийн зураг/ үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ. Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
	Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага	Барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл: ТШӨХ-д заасан.
	Захиалагчийн хяналт	- Материалын чанар стандарт, тоо хэмжээ, ажлыг хугацаандаа гүйцэтгэж байгаа эсэхэд, - Угсралтын ажлын явцад гарах зураг төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй нь хамтран шийдвэрлүүлэх.
	Барилга угсралт	Батлагдсан зураг төсвийн дагуу барилга угсралтын ажил хийж гүйцэтгэхэд: ▪ Барилга угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график, буюу хугацаат ажлын график гаргах, ▪ Талбайн зохион байгуулалтын зураглалыг ирүүлэх, ▪ Гүйцэтгэгч байгууллага нь батлагдсан зургийн дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх, ▪ Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллах, ▪ Ажлын явцад болон ажил гүйцэтгэж дуусахад гарсан хог хаягдлыг хогийн цэгт хаях ажлыг бүрэн хариуцан талбайг цэвэрлэн хүлээлгэж өгөх, ▪ Гүйцэтгэгч тал нь чанаргүй гүйцэтгэсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд БУА-г гүйцэтгэх явцад барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, тохиолдолд хүсэлтээ захиалагч, болон зургийн автор болон холбогдох байгууллагад мэдэгдэн бичгээр гаргаж зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлтийг хийж гүйцэтгэх, <i>/Зөвшилцсөн тохиолдолд өөрчлөлтийн зургийг гүйцэтгэн зурж баталгаажуулах үүрэгтэй/</i> ▪ Талбайн ажлыг гүйцэтгэхдээ бусад ажилтай үялдуулан, тухайн байршилд байгаль орчинд ээлтэй, хамгаалалтын түр хашаа хайс татах, орц гарц болон таних тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй зорчиход ямар нэгэн саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах, ▪ Оффис, амрах байрууд тус тусдаа төлөвлөгдсөн байх, ▪ Барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад талбайд буй ажилчдад ХААОБ–н хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.